



Хадлан хаших

Баян-Өлгий
аймгийн Буянт
сумын СБАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 4- 9 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, 6.430.000ТӨГ:

Төсөл хэрэгжсэн газар

Баян-Өлгий аймгийн Буянт сумын Өмөнө хөлцөөт БАХ.

Төслийн зорилго

Уг төсөл нь “Түнгэт” хэсэгт хадлангийн талбайтай болох. Хэсгийн малчдын хадлангийн талбайн доод талаас өргөжүүлэн шинээр хадлангийн талбайтай болж бэлчээрээ өнжөөж , хамгаалсан малчдын амжиргааг дэмжихээр энэхүү төслийн зорилго оршино.

Төслийн зорилтууд

1. Малчин өрхүүд нийлж шийдвэр гаргав.
- 2.Хадлангийн талбайн бүтээмжийг дээшлүүлэх.
3. Нөөц бэлчээртэй болох.
- 4.Тэжээлийн найдвартай нөөцтэй болох.
5. Бэлчээр нутгаа хамтын хүчээр хамгаалах.

Үйл ажиллагаа

- 1.Малчид шийдвэр гаргах.
2. Төсөл боловсруулах.
3. Хөрөнгө оруулагч олох
4. Хашаалах талбайн

зөвшөөрөл авах

5. Талбайн чулууг түүх.
6. Чулуу бэлдэх
7. Усалгааны суваг гаргах.
8. Чулуугаар хашаалах

Төслийн хөрөнгө оруулалт

| Хөрөнгө оруулалтын эх үүсвэр | Санхүүжилт, төгрөг |
|------------------------------|--------------------|
| Төслөөс | 1,500,000 |
| ОНХС | |
| СБАХ | |
| Малчид | 4,930,000 |
| Нийт | 6,430,000 |

Төслийн санхүүжилт буцалтгүй



Хашаалсан талбайн ургамалын бүрхэвчийн байдал



Хашаалсаны дараах байдал



Усалгааны суваг татсан байдал
Сургамж

Сумын төв орчмын багийн малчдын хадланг бод малын хөлнөөс хамгаалж хэсэг, бүлгээр нийлж хашиж, хамгаалж болдог гэдгийг харуулсан бүтээлч ажил болсон тул бусад хэсгийн малчид санаа авч хийж болох үлгэр жишээ загвар болсон байна.

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

| № | Хөрөнгө оруулалтын зарцуулалт | Хэмжих нэгж | Тоо | Нэгжийн үнэ | Нийт, төг |
|---|-------------------------------|-------------|-----|-------------|------------------|
| 1 | Усалгааны суваг татах | м | 200 | 2500 | 500,000 |
| 2 | Тариалант үеийн зардал/услах/ | | - | - | 200,000 |
| 3 | Хөдөлмөр хамгааллын зардал | ком | 5 | 40,000 | 200,000 |
| 4 | Тээврийн зардал/чулуу зөөх/ | рейс | 60 | 10000 | 600.000 |
| | Нийт | | | | 1,500,000 |

Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна.

| № | Бүтээгдэхүүн, үйлчилгээ | Хэмжих нэгж | Тоо | Нэгжийн үнэ | Нийт, төг |
|---|-------------------------|-------------|-----|-------------|------------------|
| 1 | Машин өвс | тэвш | 2,5 | 500,000 | 1,250,000 |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | Нийт | | | | 1,250,000 |

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжихээс өмнөх үетэй харьцуулахад төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүнгүүдийг тодорхой тоо баримттай, график дүрстэй оруулна. Үүнд:

- ↑ борлуулалт нэмэгдсэн байдал, **малчдын хувин хэрэгцээндээ ашиглаж байгаа**
- ↑ шинээр бий болсон бүтээгдэхүүн: **2,5 машин буюу 5 тн өвс авсан байна.**
- ↑ шинээр бий болсон хөрөнгө, **Хашаалсан 1 га талбайтай болсон**
- ↑ цэвэр ашиг,
- ↑ нийгмийн ашиг тус: **урьд онуудад өвс худалдан авдаг байсан бол одоо хаадаж авдаг болсон**
- ↑ амьжиргааны түвшин, орлого нэмэгдсэн байдал: **малчин өрхүүдийн зарлага болох 1,250,000₮ хэмнэгдсэн байгаа**
- ↑ шинээр нэмэгдсэн ажлын байр, **түр ажлын байр 6 хүн , байнгын 1 хүн ажлын байртай болсон**

үр шим хүртсэн хүмүүсийн тоо г.м



Төсөл хэрэгжүүлсэнээр Түнгэт БАХ-ын 12 өрхийг хадлангийн талбайтай болгох мөн бүлгийн 5 ядуу малчныг нэг удаагийн 400,000 төгрөгний орлоготой болгох хөдөлмөр эрхэлүүлэн амжиргааг дэмжих, улмаар малчдын хэсэг, бүлгийг дэмжиж, хамтран ажиллаж бэлчээр нутгаа хамгаалахыг урамшуулан дэмжив .

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Төслийн үр шимийг хүртсэн нэг болон нэлээн хэдэн хүн, байгууллагын өөрсдийнх нь ярьсан яриаг тухайн хүний харъяалагдах аймаг, сум, байгууллага, БАХ-ийн нэр, овог нэртэй нь бүтэн оруулж бичнэ. Зураг оруулна.

“Түнгэт” БАХ-ын ахлагч Ахайн Майра: Манай Түнгэт БАХ-ын малчдын хадлангийн талбай сумаас 5-8 км зайтай ойрхон байршилтай тул сумын төвийн айлын бод мал орж, хадлан сайн авч чаддаггүй байлаа. Хадлангаа хамгаалж зарим малчид зусландаа хугацаандаа ч гардаггүй байлаа. Тус 1га хадлангаа хашиж хамгаалсанаар 6 малчин өрх хашаалсан хадлангийн талбайтай болохын хамт, зусландаа цаг хугацаандаа гарч, өвөлжөөний бэлчээрээ эрт өнжөөж амраах боломж гарч, эдийн засгийн хөшүүрэг болсон оновчтой хөрөнгө оруулалт болсон байна. Тус талбайг цаашид өргөжүүлэхийн тулд хамтрахыг БАХ-н малчиддаа урайлан дуудаж байна. Тус төслийг хэрэгжүүлэхэд дэмжиж тусалсан аймгийн болон сумын Бэлчээр ашиглагчдын холбоо, Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хамт олонд маш их баярлалаа, ажлын амжилт хүсье.

“Түнгэт” БАХ-ын малчин Хамшыбайн Дилдаш: Тус сумын 2-р багийн Түнгэт БАХ-ын мал цөөтэй 6 малчин өрхийг хашаалсан хадлангийн талбайтай болгож, өвс тэжээлийн найдвартай эх үүсвэртэй болгосонд малчин бид туйлын баяртай байна. Хадлангаа бид өөрсдийн хүч хөрөнгөөр хамгаалах ажлыг санаачлан эхлүүлсэн боловч хөрөнгө, мөнгөний бололцоогүйгээс үр дүнд хүрч чадахгүй байсан. Харин Сумын малчдын байгууллагад хүсэлт гарган төсөл бичиж оруулсанаар бидний санаачлагыг бодит ажил болгон дэмжиж хөрөнгө оруулалт олж өгч зохион байгуулж тусалсанд талархаж байна. Хамгийн гол нь малчид хэсэг бүлгээр нэгдэж, хамтран ажиллаж, хүч хөрөнгөө нэгтгэж зохион байгуулалтанд орох нь чухал юм байна гэж ойлголоо. Мөн буцалтгүй хөрөнгө мөнгөөр дэмжлэг үзүүлсэн, санхүүжүүлэгч болох Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хамт олондоо баярлалаа.

ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

Төслийн зориулалт, зарцуулалт өөрчлөгдсөн бол учир шалтгааныг тодорхой бичиж ирүүлнэ